

**ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 03 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

1.1.Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг 1 удаа хийж 5 асуудлыг хэлэлцэж Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай, Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай, Төрийн шагналд уламжлах тухай, Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө батлах тухай тогтоолыг гаргаж биелэлтийг хангуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажиллаж байна.

Аймгийн ИТХ-аас удирдамж дагуу сумдын ИТХ-ын үйл ажиллагаа болон аймгийн ИТХ-ын шийдвэрийн хэрэгжилтийг нутгийн захиргааны байгууллагууд хэрхэн зохион байгуулж байгаад хяналт шинжилгээ үнэлгээг Эрдэнэхайрхан, Алдархаан, Дөрвөлжин, Завханмандалд сумдад хийж, Нутгийн өөрөө удирдах байгууллагуудын үйл ажиллагааны явц, холбогдох хуулинд заагдсан эрх үүргийн болон дэвшүүлсэн бодлого зорилтын биелэлт, аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс гаргасан сумдтай холбоотой шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Завхан аймаг дахь Алтан гадас одонт Цагдаагийн газраас гаргасан эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээг нэгтгэж, өссөн дүнтэй байгаа гэмт хэрэг зөрчлийг талаар бууруулах зорилт дэвшүүлж ард иргэдэд ухуулаг яриа сургалт соён гэгээрүүлэх ажлыг хийж, хууль сурталчлах дэвжээ тэмцээнийг урд бүсийн сумдад зохион байгуулсан.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон хүүхдийг түр хамгаалах байр, хохирогчид үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төвийн талаар мэдээллийг хүснэгтээр гаргаж Монгол улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах ажлын албанд хүргүүлсэн.

Алдархаан сумын иргэн В.Гансүхийн хэлцэл хийсэн материалыг Монгол улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст хүргүүлж хуулийн өөрчлөлтөд хамаарах талаар бүрдүүлэх бусад баримт бичиг, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулийн өөрчлөлтийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Сумдын ИТХ-ын дарга буюу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын дарга нарт Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах энэ ажлыг орон нутагт эрчимжүүлж ажиллах талаар үүрэг чиглэл өгч ажилласан.

2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр аймгийн ИТХ-ын Иргэний танхимд “Ус дэд хөтөлбөр”-ийн хүрээнд ундны усны аюулгүй байдлын ерөнхий төлөвлөгөөний төслийг аймгийн Иргэний нийгмийн байгууллагуудаар хэлэлцүүллээ.

Хэлэлцүүлэгт оролцсон иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдээс гарсан ундны усны нөөц газруудыг эрүүл байлгах, ундны усны аюулгүй байдлыг хангах ажлыг хэрэгжүүлэхэд Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог дэмжиж ажиллах мөн хуванцар савны хэрэглээг багасгах чиглэлээр ажил зохион байгуулах гэх зэрэг саналуудыг төсөлд тусгаж ажиллалаа.



03 дугаар сарын 01-10-ны өдрүүдэд Монгол улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд өмгөөллийн ЭмДиЭс энд ХаанЛенкс ХХН-ийн боловсруулсан “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг аймаг, сум бүр иргэд, төрийн албан хаагчдынхаа дунд хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналуудыг нэгтгэн төслийн нэгжид хүргүүллээ.



2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн Тогтвортой амьжиргаа-III төслийн хүрээнд “Орон нутгийн хөгжлийн сангийн гарын авлагын 1, 2 дугаар бүлгүүд буюу ОНХС-г төлөвлөх, төсөл арга хэмжээг эрэмбэлэх нь” сэдэвт сургалт амжилттай зохион байгуулагдлаа.

Сургалтад сумдын Засаг даргын орлогч, ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, санхүүгийн албаны дарга, багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга болон Багийн Засаг дарга нар хамрагдаж байна. 8 удаагийн сургалтад нийт 240 гаруй төрийн албан хаагч хамрагдлаа.


1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөн, уулзалтын үеэр Монгол улсын Ерөнхий Сайд, Төрийн албаны зөвлөлийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Нутгийн захиргааны байгууллагууд, аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагуудад хүргүүлж, хэрэгжүүлж ажиллах зөвлөмж, чиглэл өглөө.

Мөн Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газар болон Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлөөс шинээр батлагдсан дүрэм, журмуудыг мөрдөж ажиллах чиглэлээр албан байгууллагын дарга, удирдлагуудын “Даваа” гарагийн 3 удаагийн Шуурхай хуралдаанд сургалт, мэдээлэл хийсэн.



Энэхүү шуурхай хуралдаанд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, гишүүд “Албан тушаалын чиг үүргийн шинжилгээ хийх арга зүй”, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нь”, “Төрийн байгууллагын Стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, Төрийн албан хаагчийн Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлууд”, “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг бүрдүүлэх журам”, “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.



Шуурхай хуралдааны үеэр зохион байгуулсан сургалтанд аймгийн Засаг дарга Д.Батсайхан, Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Л.Лхамсүрэн нар “Орон нутгийн удирдах ажилтны улсын зөвлөгөөн болон төрийн албан хаагчийн удирдах ажилтны уулзалтын талаар” мэдээлэл

хийж, Засгийн газраас болон Төрийн албаны зөвлөлөөс өгсөн үүрэг даалгавар, дэвшүүлсэн бодлого, зорилтыг чанартай, үр дүнтэй хэрэгжүүлж, сахилга, хариуцлагыг бүх шатанд өндөржүүлж ажиллахыг анхаарууллаа.



Мөн сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагууд, төрийн байгууллагын дарга, удирдлагууд, Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд 2019 оны 03 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд тусгай хөтөлбөрийн дагуу Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүд дээрх сэдвүүдээр сургалт хийж, уулзалт ярилцлага зохион байгууллаа.

Тус аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 2019 оны 03 дугаар сард нийтдээ 9 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 500 гаруй албан хаагч хамрагдлаа.



Төрийн албаны зөвлөлөөс өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж, төрийн байгууллагуудад “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал батлах тухай” Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу “Чиг үүргийн шинжилгээ”, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу “Ажлын байрны шинжилгээ” тус тус хийх ажлын хэсгийг томилон ажиллуулж байна.

Нутгийн захиргааны байгууллагууд, аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагууд, төрийн байгууллагуудад шинээр батлагдан гарч буй УИХ-ын болон Засгийн газрын, Төрийн албаны зөвлөлийн тогтоол шийдвэрүүдийг судлан Ажлын байрны шинжилгээ хийж, Албан тушаалын тодорхойлолт, байгууллагын болон Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан Хувийн хэргээ шинэчлэх, Ёс зүйн зөвлөл байгуулах зэрэг асуудлуудаар үүрэг чиглэл, зөвлөмж хүргүүлээд байна.

“Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр албан даалгаврыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 03 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанд танилцуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан албан даалгаврын хамт төрийн байгууллагуудад хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү албан даалгаврыг тус аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг “шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хугацаа, хариуцах байгууллага, албан тушаалтан” агуулгын хүрээнд боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргаар батлуулан Төрийн байгууллагын дарга, эрхлэгч болон сумдын Засаг дарга нарт салбар зөвлөлийн 2019 оны 21 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.

Төрийн шагналт, Монгол улсын Гавьяат зүтгэлтэн, дорнын их яруу найрагч Б.Явуухулангийн мэндэлсний 90 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Явуу-90” ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг найрагчийн төрсөн нутаг Алдархаан сумын нутаг Ар амны Тасархайн бууцанд 2019.03.15-нд аймгийн Засаг даргын Тамгын газар, утга зохиолын нэгдэл, Жавхлант хийморь хоршоо, Ерөнхий боловсролын лаборатори Чандмань-Эрдэнэ сургууль хамтран зохион байгууллаа.



Тус арга хэмжээнд аймгийн болон Алдархаан сумын удирдлага, Дорнын их яруу найрагч Бэгзийн Явуухулангийн мэндэлсний 90 жилийн ойг зохион байгуулах ажлын



хэсгийн гишүүд, ард иргэд, Ерөнхий боловсролын лаборатори Чандмань-Эрдэнэ сургуулийн багш, ажилтнууд, ахлах ангийн суралцагчид зэрэг 300 гаруй зочид төлөөлөгчид оролцлоо.

Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн П.Батсайханы зохиолоор бүтсэн “2000” уран сайхны киноны нээлтийн үйл ажиллагааг аймгийн ХЖТ-д хийж МУГЖ Цэрэндагва, МУСТА Цэрэнболд нарын урлаг соёлын алдартнууд, аймгийн удирдлагууд оролцлоо. Тус кино нь Улиастай хотын түүхэн 2000 цэргийн бослого, тэмцлийг харуулсан уран сайхны кино бөгөөд Улаанбаатар хотод нээлтээ хийж, кино театруудаар гарч эхэлсэн бөгөөд 03 дугаар сарын 17,18-ны өдрүүдэд аймгийн ХЖТ-т гарч, үзэгчдийн хүртээл боллоо.



Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Хүчирхийллийн эсрэг нэгдье” уриан дор бүх нийтийн алхалт, эмэгтэйчүүдээ сонсьё зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Охид эмэгтэйчүүдийн хүчирхийллийн

эсрэг, эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх бүх нийтийн алхалтанд 2000 гаруй хүн оролцлоо.

Бүх нийтийн алхалт, тайван жагсаалд иргэд сайн дураараа нэгдэж охид эмэгтэйчүүдээ хайрлая, эмэгтэйчүүд нийгмийн бүхий л салбарт эрхээ хамгаалуулах эрхтэй, охидын хүчирхийлэл



үйлдэгчийг тэвчихгүй, хүчирхийллийг хүчирхийлэгч өөрөө зогсоож чадна уриа лоозон барьж жагссан.

Эмэгтэйчүүдээ сонсьё арга хэмжээнд 400 гаруй эмэгтэй оролцож эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр тулгамдаж буй асуудлуудаа нээлттэй хэлэлцэж шийдвэр гаргах түвшний удирдлагуудад санал, хүсэлтээ уламжиллаа.

Уг арга хэмжээг төр, төрийн бус байгууллагын түншлэлийн хүрээнд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 15 төрийн бус байгууллагууд хамтран зохион байгуулсан.



“ITM-2019” Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 20 дахь жилдээ Улаанбаатар хотын Мишээл Экспо төвд амжилттай зохион байгуулагдаж, үзэсгэлэнгийн ерөнхий зохион байгуулагчаар Монголын Аялал Жуулчлалын Холбоо, хамтран зохион байгуулагчаар БОАЖЯ, албан ёсны түнш Увс аймаг, дэмжигч байгууллагаар Нийслэлийн Аялал жуулчлалын газар,

Туркиш Эйрлайнс ХХК ажилласан.

Энэхүү үзэсгэлэнд Завхан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Завхан аймгийн Аялал жуулчлалын холбоо, Мөнхөд мандаг ХХК, Улиастай зочид буудал, Skyline зочид буудал, Сайхан төгөл, Хожуулын гол, Замбага, Энх-Өвөгдий, Хар нуур, Их тэнгэрийн хүрээ, Баяннуур, Оргих, Их Монгол, Эрээн нуур зэрэг жуулчны баазууд аймаг орон нутгаа сурталчлан амжилттай оролцлоо.



Завхан аймаг эрүүл мал бүхий аймаг байх зорилтоо амжилттай хэрэгжүүлж, Солонготын даваа, Согоотын даваанд малын эрүүл мэндийн хяналтын байнгын цэг байгуулан ажилласнаар малын халдварт өвчингүй аймаг болоод байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Сайн малчин” дэд хөтөлбөрийнхөө хүрээнд малын эрүүл мэндийн мөшгих тогтолцоог 24 сумандаа нэвтрүүлэхээр тусгасан юм. Малын эрүүл мэндийн мөшгих тогтолцоог нэвтрүүлэхэд 1. Малчдад маш сайн

мэдээлэл хүргэж, хамтын ажиллагааг өргөжүүлэх 2. Сумуудаа тоног төхөөрөмжөөр хангах 3. Эрүүл мал бүхий аймаг болохоо олон нийтэд хүргэх замаар хэрэглэгчдийг эрүүл хүнсээр хангах асуудал чухал юм.

Малын эрүүл мэндийн мөшгих тогтолцоог 24 суманд нэвтрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авахад шаардагдах 105 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр шийдсэн.

Малчдад малын эрүүл мэндийн мөшгих тогтолцооны талаарх нэгдсэн ойлголтыг өгөх, малчдынхаа санал бодлыг сонсох зорилгоор 3, 4 дүгээр саруудад 24 суманд “Сумын малчдын зөвлөгөөн” зохион байгууллаа. 5 дугаар сард баг бүрээс малчдаас төлөөлөн сонгогдсон 350 гаруй малчныг оролцуулсан “Аймгийн малчдын зөвлөгөөн” зохион байгуулахаар шийдвэрлээд байна.


Монгол улсад шинэ үеийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 98 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу Завхан аймагт үйл ажиллагаагаа явуулдаг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудыг хамруулан тэдний хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, бие бүрэлдэхүүний ур чадвар, албаны бэлэн байдлыг дээшлүүлэх, байгууллагынхаа онцлог үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах боломжийг нээж өгөх зорилгоор аймгийн Засаг даргын 2019 оны А/47 дугаар захирамжаар ажлын хэсэг гаргуулан баярыг тэмдэглэн өнгөрүүллээ.

Монгол улсад шинэ үеийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 98 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан Монгол Улсын баатар, армийн генерал Батын Дорж агсаны хөшөөнд цэцэг өргөх болон спортын арга хэмжээ аймгийн усан бассейн бүхий спорт цогцолборт явагдаж, усанд сэлэлт, шатар,



100 буудалт даам, ширээний теннис, дартс зэрэг тэмцээн уралдаанууд зохион байгууллаа.

“Монгол цэргийн өдөр”-ийн нэрэмжит спортын 8 төрлийн тэмцээн уралдаанд аймгийн УАБ-ыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын төлөөлөл 13



байгууллагын давхардсан тоогоор 300 гаруй тамирчид төрөл тус бүрт хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдөж аваргууд тодорлоо. Багийн дүнгээр Зэвсэгт хүчний 325 дугаар анги 1-р байр, аймгийн Цагдаагийн газар 2-р байр, аймгийн Онцгой байдлын газрын баг тамирчид 3-р байрт тус тус шалгарлаа. Энэ жил тэмцээн уралдааны төрөлд усанд сэлэлтийн төрлийг оруулсан нь онцлог бөгөөд олны сонирхол, өрсөлдөөнийг нэмэгдүүлсэн байлаа.

2019 оны 03 дугаар сарын 16-ны өдөр марш тактикийн аварга тасаг шалгаруулах тэмцээн зохион байгуулсан. Тэмцээнд 7 байгууллагын 8 тасаг оролцсоноос хурандаа Г.Чулуунзагд захирагчтай Зэвсэгт хүчний 325-р ангийн тасаг 1-р байр, хурандаа Ө.Болд захирагчтай аймгийн Онцгой байдлын газрын тасаг 2-р байр, хурандаа Г.Баярхүү захирагчтай Хилийн 0277 дугаар ангийн тасаг 3-р байр тус тус эзэллээ.



Энэ жилийн арга хэмжээний нэг онцлог бол Улиастай сумын Ерөнхий боловсролын сургуулиудын дунд маршийн тэмцээнийг зохион байгуулан явуулсан бөгөөд арга хэмжээнд 5 сургууль оролцож Улиастай сумын 4-р сургуулийн тасаг тэргүүн байрт шалгарсан.

Монгол Улсын Дайчилгааны тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Засгийн газрын 2018 оны 376 дугаар тогтоолоор батлагдсан “Аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах бүрэлдэхүүнтэй сургалт, дадлага явуулах журам”-ын холбогдох заалтыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2018 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт орон нутагт батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, ажил үүргээ гүйцэтгэхэд нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, батлан хамгаалах



салбарын хууль эрх зүйн шинэчлэл, бодлого үйл ажиллагааг сурталчилан таниулах, орон нутаг дахь хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэх зорилгоор 2019 оны 03 дугаар сарын 11, 12, 13-ны өдрүүдэд сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийг боловсруулах арга зам” сэдэвт цэргийн бэлтгэл сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Батлан хамгаалахын сайдын 2018 оны Н/26 дугаар тушаалаар батлагдсан орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах зааврын дагуу сумын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулах, Батлан хамгаалахын сайдын 2018 оны МН/25 дугаар тушаалаар батлагдсан томилгоот нэгжийн бүтэц, зохион байгуулалтын үлгэрчилсэн загварт тулгуурлан орон нутгийн онцлогт тохируулан орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүтэц зохион байгуулалтыг тогтоох ажлыг хэрэгжүүлэх арга зүйгээр ханган ажилласан.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу Аймгийн засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2019 оны 03 дугаар сарын 18-22-ны өдрүүдэд Ховд аймагт байрлах Зэвсэгт хүчний 123, Баян-Өлгий аймагт байрлах Зэвсэгт хүчний 340, Увс аймагт байрлах Хилийн 0311 дүгээр ангийн 6 заставт ажиллалаа.

Завхан аймгаас цэргийн алба хааж буй цэрэг дайчидтай сар шинийн золголтын арга хэмжээг зохион байгуулж, цэргийн албан хаагчдын алба хааж буй орчин нөхцөл, албаны үйл ажиллагаатай танилцсан.



Аймгийн Засаг дарга цэргийн алба хаагчдад аймаг орон нутагт хийж хэрэгжүүлж буй ажил, бүтээн байгуулалт, нутаг орны цаг улирлын нөхцөл байдал зэрэг мэдээ, мэдээллийг хүргэж, сум орон нутгийн удирдлагын мэндчилгээ, аав, ээжийнх нь амар мэндийг дамжуулж өөрийн гарын бэлэг, ар гэрээс явуулсан бэлэг, захидлыг гардуулан өгч тэдний санаа сэтгэгдлийг нь сонсон, ахуй нөхцөл, сургалт бэлтгэлийн явцтай танилцаж, аймгийн ХЖТ-ийн уран бүтээлчдын урлагийн тоглолтоор үйлчиллээ. Энэ удаагийн бүрэлдэхүүнд “Тусгай салаа” киноны Дэндэвийн дүрээр олонд танигдсан дуучин, жүжигчин Эрдэнэбаяр багтаж явсан нь цэрэг дайчдад гэнэтийн бэлэг болж байснаар онцлог болсон.



Япон Улсын Засгийн газрын "Өвсний үндэс" хөтөлбөрийн санхүүжилтээр Завхан аймгийн Баянхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажлыг гүйцэтгэх гэрээнд 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдөр гарын үсэг зурлаа

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

2.1.Татвар төлөлтийн байдал: Татварын орлогын төлөвлөгөө аймгийн дүнгээр 114.6 хувийн биелэлттэй, 1 тэрбум 227.5 сая төгрөгийн орлого оруулсаны цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 56.3 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 3.5 хувь, аж ахуйн нэгж байгууллагын албан татвар 1.2 хувь, хүн амын орлогын албан татвар 21.3 хувь бусад нэр төрөл 17.7 хувийг тус тус эзэлж байна. Нийт татварын орлогын бүрдүүлэлтийн 93.4 хувь буюу 1 тэрбум 147.2 сая төгрөгийг орон нутгийн орлого, 6.6 хувь буюу 80.3 сая төгрөгийг улсын төсвийн орлого бүрдүүлж байна.

Монгол банкны мэдээгээр эхний 2 сард 311.2 сая төгрөг гүйлгээнд гарч, иргэдийн мөнгөн хадгаламжинд 67.2 мянган иргэний 89.8 тэрбум төгрөг байгаа нь иргэдийн мөнгөн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 16 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аймгийн дүнгээр 17.3 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 6 тэрбум төгрөгөөр буурсан байна. Зээлийн сарын хүүг арилжааны банкуудаар авч үзвэл дунджаар ХААН банк 1.3 хувь, Хас банк 0.58-2.0 хувь, Төрийн банк 1.8 хувь, Капитал банк 1.5 хувь байна.

Гурав. Хууль зүйн бодлогын хүрээнд:

3.1. Хууль хяналтын үйл ажиллагаа: “Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын удирдамжийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын орон тооны бус салбар зөвлөлийн даргаар батлуулж, удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг” ТББ нар хамтран хяналт шалгалт зохион байгууллаа.

Хяналт шалгалтаар сургуулийн ойр орчимд байгаа хүнсний дэлгүүр, цайны газарт үйл ажиллагаа явуулах эрхийн гэрчилгээтэй эсэх, хүнсний аюулгүй байдал,

сав баглаа боодол, хугацаа, чанар, стандарт шаардлагад нийцэж буй зэргийг шалган илэрсэн зөрчлийг арилгуулах санал, зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Мөн **“Аюулгүй, ухаалаг бараа, бүтээгдэхүүн”** сэдвээр Ерөнхий боловсролын сургуулийн 5-9 дүгээр ангийн давхардсан тоогоор 800 гаруй хүүхдэд сургалт мэдээлэл зохион байгууллаа. Сургалтаар Мэргэжлийн хяналтын Хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагчид, “Цахим гэмт хэрэг”-ээс урьдчилан сэргийлэх Цагдаагийн газрын Ахмад Т.Амарбаяр, Ахлах дэслэгч Б.Базарсад нар мэдээлэл хийлээ.

3.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл: Аймгийн хэмжээгээр эхний 2 сард 57 гэмт хэрэг гарсаны 21.1 хувийг иргэдийн эрх чөлөө эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 43.9 хувь нь бусдын өмчийн өмчлөлийн эсрэг гэмт хэрэг, 35.0 хувийг бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Эхний 2 сард 1925 зөрчил илрүүлж, 85 хүн эрүүлжигдэн, 12 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчил 1179, эрүүлжигдсэн хүн 23-р тус тус өсч, баривчлагдсан хүн өмнөх оны түвшинд байна.

3.3. Архивын ажлын мэдээлэл: Ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд 12 хөмрөг, 12 данс, 198 хадгаламжийн нэгжийн 10700 хуудас баримтыг сканердаж, 12 хөмрөг 12 дансны 198 хадгаламжийн нэгж, 8788 хуудас баримтыг photoshop програмд засварлалаа.

5 хөмрөгийн удирдлагын баримт бичгийг баримтын түвшинд тодорхойлон бичих, тоо бүртгэлийн програмд оруулах ажлын хүрээнд 5483 хуудас баримтаас 3173 заалт, 18019 хүний нэр, 47 газар зүйн нэр программд шивж 72 PDF файл үүсгэн эх баримтыг холболоо.

154 иргэн, 5 байгууллагын хүсэлтийг хүлээн авч 488 баримт шүүж, 123 хуулбар, 79 лавлагаа 43 тодорхойлолт олгож төрийн үйлчилгээ үзүүллээ.

Архивын баримтын тоо бүртгэлийн нэгдсэн программд 163 байгууллагын мэдээг шивж, баталгаажуулан аймгийн нэгдсэн мэдээг гаргаж Архивын ерөнхий газарт хүргүүллээ.

14 хөмрөгийн 205 хадгаламжийн нэгж баримтыг иж бүрэн нягтлан шалгаж техник боловсруулалт хийсэн.

Аймгийн барилгачдын зөвлөгөөнд: Барилгын норм ба дүрмийн дагуу боловсруулсан ажлын зургаар эрх бүхий хуулийн этгээдийн барьсан бүх төрлийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний зураг төсөл холбогдох баримт бичгийг төрийн архивт шилжүүлэхэд, архивын баримтыг эмхэлж ангилан

төрөлжүүлж хадгаламжийн нэгж үүсгэх, түүнд тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээний талаар семинар өгсөн.

Төрийн архивыг 2019 онд нөхөн бүрдүүлэх төлөвлөгөө, хуваарийн дагуу 11 хөмрөгөөс 2018 оны мал тооллогын бүртгэл 86 хадгаламжийн нэгж, 2 хөмрөгөөс удирдлага зохион байгуулалтын 71, нийт 137 хадгаламжийн нэгж баримтаар нөхөн бүрдүүлэлт хийлээ.

3.4. Онцгой байдал: Улсын Онцгой комиссын Шуурхай бүлэгт аймгийн Засаг



дарга 2018-2019 оны өвөлжилт, хаваржилтийн нөхцөл байдал, орон нутгаас авч хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээлэл хийж аймгийн онцгой комиссыг хуралдуулсан.

Засгийн газрын шийдвэрээр 900 тонн өвс, 680 тонн тэжээл, Цагаанхайрхан суманд түргэн тусламжийн автомашин, Яруу,

Тосонцэнгэл, Тэс сумын Засаг даргын Тамгын газарт автомашин олгохоор тус тус шийдвэрлэснийг танилцуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 82 дугаар тогтоолын дагуу Завхан аймаг дахь Улсын нөөцийн салбарын өвс тэжээлийн 6 цэгээс өвс 3465 боодол буюу 69,3 тонн, хивэг 7702 шуудай буюу 192.5 тонн, хорголжин 196 шуудай буюу 7.8 тонн өвс тэжээлийг 50%-ийн хямдралтай үнээр Аймгийн засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн баталсан хуваарийн дагуу 24 сумын 116 багийн малчид, мал бүхий иргэдэд олгоод байна.

Онцгой байдлын газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн баталсан удирдамжийн дагуу Тэс сум дахь гал түймэр унтраах, аврах 57 дугаар ангийн өдөр тутмын үйл ажиллагааг шалган зааварчлах ажлын хэсэг 03 дугаар сарын 10-ны өдрөөс 11-ний өдрүүдэд тус ангид ажиллаа.

Энэ сард график төлөвлөгөөний дагуу Монгол улсын Шадар сайдын баталсан удирдамжийн төлөвлөгөөт хяналт шалгалтаар хүн ам олноор цуглардаг худалдаа олон нийтийн **13** байгууллагууд,

Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар модон хийц бүхий сургуулийн өмнөх насны боловсрол олгох **6** байгууллага,

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар **5** аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм стандартын хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтыг зохион явууллаа.

Хяналт шалгалтаар нийт **24** газар хамрагдсанаас зөрчил дутагдлуудыг арилгуулахаар байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага **10** мэдэгдэл **6** тус тус үйлдэн хүргүүлж, шалгалтын дүнгийн талаар шалгалтад хамрагдсан газруудын удирдлагуудад танилцуулж, зөрчлийг арилгах талаар мэргэжил арга зүйн заавар зөвлөмж өгч ажиллаа.

Тосонцэнгэл сумын Хайрхан, Дархан-Уул баг, Тэс сумын Зүр зэрэг **5** багийн гэр хорооллын нийт **900** айл өрхөд галын аюулгүй байдлыг хангуулах үзлэг шалгалтыг зохион явууллаа.

Хяналт шалгалтын үр дүнд гал түймэр гарч болзошгүй давхардсан **148** зөрчил илрүүлснээс газар дээр нь **39** зөрчлийг арилгуулан бусад зөрчлүүдийг арилгах чиглэл болон галын аюулаас урьдчилан сэргийлэх арга ажиллагааны талаар **3700** иргэнд мэргэжил арга зүйн заавар зөвлөмж, ухуулга сурталчилгаа зохион байгуулж ажиллаа.

Урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг аймгийн Прокурорын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Нэгдсэн эмнэлэг, Богдын гол усан цахилгаан станц зэрэг газруудын нийт 140 алба хаагчдыг хамруулан ажлын байрны галын аюулгүй байдал сэдвээр 6 цагийн танхимын болон дадлага сургууль зохион явуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, аймгийн Барилгачдын холбоотой хамтран аймагт үйл ажиллагаа эрхэлж буй барилга угсралт гүйцэтгэлийн аж ахуйн нэгжийн холбогдох 40 гаруй мэргэжилтнийг хамруулан Галын аюулгүй байдлыг хангах талаарх норм, стандартын хэрэгжилтийн байдлын талаар мэдээлэл хийсэн.

Тэс сумын Соёлын төвд 03 дугаар сарын 11-ний өдрийн 10 цагт сум орон нутгийн удирдлага, 60 гаруй ард иргэдэд Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, сурталчилан таниулах, сургалтыг зохион байгуулсан.

Онцгой байдлын газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн баталсан Гэр хорооллын галын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн удирдамжийн хүрээнд 2019 оны 03 сарын 09-10-ны өдрүүдэд Тэс сумын **310** айл өрхийг хамруулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж **1550** иргэнд галын аюулаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж өгч **915** зөрчил дутагдалыг илрүүлж **50** зөрчил дутагдалыг газар дээр нь засуулж гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан

сэргийлэх гарын авлага боршур 1350 ширхэгийг тарааж галын түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөмж өгсөн.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

4.1. Боловсрол, соёлын чиглэлээр: Монголын багш нарын VII их хуралд төлөөлөгч сонгох ажлын хэсэг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдаж, төлөөлөгч сонгох зааврын дагуу хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиас ирүүлсэн 74 багш, ажилтнаас сонгож, төлөөлөгчөөр сонгогдсон 27 багш, ажилтны мэдээллийг яаманд хүргүүллээ.

Хэлний бодлогын Үндэсний зөвлөлийн Завхан аймаг дахь Салбар зөвлөл 2019.03.05-нд хуралдаж, салбар зөвлөлийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлэлцэн баталж, долоо хоногийн Лхагва гаргийг “Эх хэлний өдөр” болгон тэмдэглэх тухай аймгийн Засаг даргын захирамж гарлаа.

"Эх хэлний өдөр"-ийн хүрээнд албан байгууллагууд ажилтан албан хаагчдынхаа найруулан бичих, зөв бичих зүйн ур чадварыг дээшлүүлэх, үндэсний хэл, бичгийн сургалтад хамруулах, байгууллагаараа “Хүмүүн бичиг”-тэн болох, үндэсний бичиг сайн эзэмшигч иргэний үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, ард иргэдийн гар дээр буй үндэсний бичгээр бичигдсэн судар номыг сурвалжлан цуглуулах, үзэсгэлэн гаргах, хаягжилт, үзүүлэн самбар, нэрийн хуудас, танилцуулга, өргөмжлөл дурсамж, мэндчилгээ, урилга, талархал зэргийг хос бичгээр бичих үйл ажиллагааг зохион байгуулах удирдамжийг албан байгууллагуудад хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын нэрэмжит математикийн 17 дахь олимпиад "Оюуны наадам"-ыг IV/29-V/13-нд зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийг боловсруулан, зэргэлдээх аймгийн Засаг дарга нарт урилга, удирдамжийг хүргүүллээ.

Хаврын мал төллөлттэй холбогдуулан сумдын удирдлага, ард иргэдийн саналыг харгалзан аймгийн Засаг даргын захирамжаар Асгат, Цэцэн-Уул, Отгон, Ургамал, Шилүүстэй сумын ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын гуравдугаар улирлын амралтыг 7 хоногоор урагшлуулж, 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаагаар амраах зохицуулалт хийлээ.

Энэ онд түүхэн тэгш ой нь тохиож байгаа сургууль, цэцэрлэгийн ой тэмдэглэх зөвшөөрөл хүссэн хүсэлтийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралд уламжлан, албан бичиг хүргүүллээ. Сурган заах арга зүйн кабинет үүсч хөгжсөний 60 жилийн ойн ажлын хүрээнд аймгийн БСУГ-ын хамт олны төлөөлөл

2019 оны 03 дугаар сарын 11-15-нд Улаанбаатар хотод амьдран суудаг ахмад багш, ажилтнуудтайгаа уулзалт зохион байгуулж, санал бодлоо солилцлоо.

Боловсрол,соёл шинжлэх ухаан спортын сайдын 2019 оны А/42 тоот тушаал, Ерөнхий боловсролын бодлогын газрын даргын 2019 оны 4/1487 тоот албан бичгийн дагуу 2019 онд их, дээд сургуульд элсэн суралцах хүсэлтэй иргэдээс Монгол хэл, бичгийн шалгалтыг Боловсролын үнэлгээний төвийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй хамтран 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгууллаа.

Шалгалтанд 482 иргэн бүртгүүлснээс 455 иргэн хамрагдаж, 49 анги танхимд 49 хянагч багш, 6 мэргэжилтэн зохион байгуулагчаар ажиллалаа.

Боловсролын үнэлгээний төвөөс 2019 оны 03 дугаар сарын 20,21-нд зохион байгуулсан чанарын үнэлгээний судалгаанд сонгогдсон Улиастай сумын Ерөнхий боловсролын Чандмань-Эрдэнэ лаборатори сургууль, 4-р сургууль, Тосонцэнгэл сумын лаборатори 1-р сургуулийн 3,9,10-р ангийн суралцагчдаас Математик, монгол хэл, физик, англи хэл, байгаль шинжлэлийн хичээлээр шалгалт авлаа. Таван бүсийн 24 сургуульд чанарын үнэлгээний шалгалтыг БСУГ-ын мэргэжилтнүүд, Улиастай сумын Ерөнхий боловсролын сургуулиудын захирал, сургалтын менежерүүдтэй хамтран зохион байгуулж, шалгалтад 3-р ангийн 253, 9-р ангийн 1088 ,10-р ангийн 203 суралцагч хамрагдлаа.

Улсын төрөлжсөн 2 дугаар шатны 12 төрлийн олимпиадад Ерөнхий боловсролын сургуулийн 1960 гаруй суралцагч, 1000 гаруй багш оролцлоо.

Олон Улсын эмэгтэйчүүдийн баярын өдрийг тохиолдуулан Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дунд зохион байгуулсан “Ээжээ тандаа баярлалаа” шилдэг захидал болон гар зургийн уралдаанд 560 гаруй суралцагчийн бүтээл сум, сургуулиасаа шалгаран оролцсноос гар зураг, захидлын уралдааны бага, дунд, ахлах ангийн төрөл бүрт 31 суралцагчийн бүтээл шагналт байранд шалгарлаа.

Сургуулийн өмнөх боловсролын багш нарын дунд Монгол хэл бичгийн анхдугаар олимдиадыг зохион байгуулж, 37 багш оролцлоо.

БСШУС-ын яамнаас Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн IV шатны сургалтыг 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаатай ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, нягтлан бодогч, бага боловсролын багш нийт 365 хүнд зохион байгууллаа.

Сургалтаар сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 4 дүгээр шат ба гарын авлагын танилцуулга, онцлог ялгаа, өмнөх шатны сургамж, санхүүжилтийн урсгал, тайлагналт, худалдан авалт, чиглэл тус бүрээр үлгэрчилсэн төслийн санал бэлтгэж, тайлагнах, төслөөс хийгдэх ойрын үеийн ажлын мэдээллийг өгч, дүгнэлт, санал, асуулт ярилцлага хийлээ.

Аймгийн Засаг даргын санаачилгаар хэрэгжүүлж буй малчдын 6 настай хүүхдэд зориулсан “Гэр өргөө”-ний багш нарт “Бага насны хүүхдийн нас сэтгэхүйн онцлог”, “Зөв бичих дүрэм”-ийн сургалтыг БСУГ-аас 2019 оны 03 дугаар 25-26-ны өдрүүдэд ерөнхий боловсролын ЧЭЛС дээр зохион байгуулж, “Гэр өргөө”-ний 18 багш хамрагдлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн орос хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх 2 өдрийн сургалтыг БСУГ, Орос хэлний “Завь-русь” төвтэй хамтран зохион байгуулж, 20 багш оролцлоо.

Бага насны хүүхдийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн зөв зан үйлд сургах, арга зүйн хөгжилд дэмжлэг үзүүлэх, зөв дадал хэвшил, мэдлэг чадвар эзэмшүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролын багш нарт “Эрүүл мэнд эрхэм баян” сургалтыг БСУГ, ерөнхий боловсролын эмч, бага боловсролын арга зүйн багтай хамтран 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Улиастай сумын ерөнхий боловсролын 3-р сургууль дээр зохион байгуулж, 500 гаруй багш хамрагдлаа.

4.2.Эрүүл мэнд, спортын чиглэлээр: Аймгийн хэмжээнд 3 сарын 1-ний байдлаар 218 эх амаржиж, 217 хүүхэд амьд төрж, 55 хүн нас барж, нэг хүртэлх насны хүүхэд 4 эндэж, нийт 94 халдварт өвчин бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төрсөн эх 12(94.7%)-оор, нас баралт өнгөрсөн оны мөн үеээс 10(84.6%)-аар тус тус буурч, нийт халдварт өвчлөл 41(229.2%)-ээр, халдварт бус өвчлөл 1735(118.4%)-аар тус тус нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд эхний 2 сард 3.3 мянган өвчтөнийг 23.7 мянган ор хоногоор хэвтүүлж эмчлэн, 56.4 мянган хүнд амбулаториор үйлчилж, 252 жирэмсэн эхийг шинээр хяналтанд авсан байна.

Эрүүл мэндийн яамны ажлын хэсэг Завханмандал сумын сум дундын эмнэлэг, Дөрвөлжин, Яруу, Цэцэн-Уул, Баянхайрхан сумын эрүүл мэндийн төв, Дөрвөн оноо өрхийн эрүүл мэндийн төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагуудад “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам”-ын дагуу магадлан итгэмжлэлийн үнэлгээ шинжилгээг хийлээ.

Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 03 дугаар сарын 22-ны өдөр "Инээмсэглэл–Эерэг хандлага" уриан дор зохион байгууллаа.

Зөвлөгөөнд 29 байгууллагын 46 удирдах албан тушаалтан оролцож, салбарын хөгжлийн чиг хандлага, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг дүгнэж, 2018 оны гүйцэтгэлийн үнэлгээний дүнг танилцуулж 2018 оны үйл ажиллагаагаараа шалгарсан 5 сумын Эрүүл мэндийн төв, Уламжлалт анагаах ухааны төв, Зооноз судлалын төвийн дарга нарыг урамшууллаа.

Мөн 2019 оны салбарын хэмжээнд дэвшүүлж буй зорилт, арга хэмжээ, шинээр мөрдөгдөж буй хууль, дүрэм журмыг танилцуулж, Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс даатгалын санхүүжилттэй холбоотой мэдээлэл хүргэн, удирдах ажилтнуудтай санал солилцсон байна.

Эрүүл мэндийн салбар 2019 оныг "Инээмсэглэл–Эерэг хандлага"-ын жил болгон зарласантай холбогдуулан АШУҮИС-ийн НЭМС-ийн багш нартай хамтран “Эрүүл мэндийн удирдлага, манлайлал”, “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага” сэдэвт 4 багц цагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 400 гаруй эмч мэргэжилтэн хамрагдсан байна.

Гэмтэл согогын үндэсний төв, Геронтологийн төв аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран багц цагийн сургалтуудыг зохион байгуулж эрүүл мэндийн салбарын эмч ажилчдын 30 гаруй хувь нь 2-4 багц цагийн сургалтад хамрагдаад байна.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Эмч нарын нэрэмжит “Эрүүл мэндийн олимпиад”-ийг 14 дэх жилдээ “Эрүүл мэндийн суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж”-ийн хүрээнд тест, эсээ бичлэгийн төрлөөр амжилттай зохион байгуулж, эхний 3 байрыг шалгаруулан шагнаж урамшууллаа. Дэвшил ЕБС амжилттай оролцон бусдыгаа манлайлан шалгарч, шилжин явах цом, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Биеийн тамир, спортын салбарт

2019 оны Хүүхдийн спортын YI наадмын хүрээнд зохион байгуулагдсан “Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Цана, сагсан бөмбөг, шатар, даам, самбо, жүдо бөх, чөлөөт бөх, ширээний теннис, волейбол, теквондо гэсэн 10 төрлөөр зохион байгуулж 18-н сумын ЕБ-ын сургуулийн 1000 гаруй тамирчид амжилттай оролцлоо.

“Өсвөрийн волейболын баруун бүсийн аварга” шалгаруулах тэмцээн Говь-Алтай аймагт зохион байгуулагдаж эмэгтэй шигшээ багийн тамирчид 2-р байранд орж Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авсан.

Сагсан бөмбөгийн U-18 насны Улсын аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотод зохион байгуулагдаж 21 аймаг 9 дүүргийн 350 гаруй тамирчид

оролцлоо. Аймгийн сагсан бөмбөгийн залуучуудийн шигшээ багийн тамирчид мөнгөн медаль хүртэж 7 тамирчин спортын 1 дүгээр зэргийн болзол хангасан амжилттай байна.

Нийгмийн даатгал, халамж

Аймгийн хэмжээгээр нийгмийн даатгалын сангаас эхний 2 сард 11.1 мянган хүнд 7.6 тэр бум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, 2.3 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Эхний 2 сард 10655 хүн нийгмийн даатгалд хамрагдсаны 8013 буюу 75.2 хувь нь төсөвт байгууллага, ААНэгж байгууллагын даатгуулагч, 2642 иргэн буюу 24.8 хувь нь сайн дурын даатгалд хамрагдсан байна.

Сангуудаар авч үзвэл: ҮОМШӨ сангийн орлогын төлөвлөгөөг 10.1 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 5.9 хувиар давуулан биелүүлж, тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 14.8 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 10.6 хувиар тасарсан байна.

Тэтгэвэрийн сангийн зарлага 6974.8 сая төгрөгт, Тэтгэмжийн сангийн зарлага 162.4 сая төгрөг, Эрүүл мэндийн сангийн зарлага 310.0 сая төгрөг, ҮОМШӨ-ний зарлага 85.7 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалийн сангаас 38.8 сая төгрөг тус тус зарцуулж нийт 7571.7 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, даатгалыг олгосон байна.

Халамжийн сангийн үйл ажиллагааны мэдээгээр Халамжийн тэтгэвэр 1757 хүнд 550.2 сая төгрөг, нөхцөлд мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт, тусламж 23514 хүнд 1829.2 сая төгрөг нийт 25271 хүнд 2379.4 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийг орон нутгийн сан болон улсын төсвийн санхүүжилтээр үзүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлт

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй хүний тоо 1005 болж, өнгөрсөн оны мөн үеэс 42.5 хувиар буюу 744 хүнээр буурсан байна. Аймгийн хэмжээнд 525 эмэгтэй ажил идэвхтэй хайж байгаа нь бүртгэлтэй ажилгүйчүүдийн 52.2 хувийг эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 13.7 хувь нь 15-24 нас, 33.1 хувь нь 25-34 нас, 28.7 хувь нь 35-44 нас, 19.9 хувь нь 45-54 нас, 4.1 хувь нь 55-59 нас, 0.5 хувь нь 60-аас дээш насны ажилгүйчүүд байна.

Ажилгүйчүүдийн 1.5 хувь нь боловсролгүй, 2.6 хувь нь бага, 7.8 хувь нь суурь, 53.3 хувь нь бүрэн дунд, 6.1 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.9 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 23.8 хувь нь дээд боловсролтой хүмүүс тус тус эзэлж байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд: Асгат, Дөрвөлжин, Идэр, Нөмрөг, Сантмаргаз, Тосонцэнгэл, Түдэвтэй, Улиастай, Цагаанхайрхан, Цэцэн уул зэрэг 10 сумын мал эмнэлгийн тасгийн дарга улсын байцаагч, Алдархаан, Баянтэс, Идэр, Их уул, Санмаргаз, Тосонцэнгэл, Түдэвтэй, Тэлмэн, Тэс, Улиастай, Ургамал, Цагаанчулуут, Шилүүстэй, Эрдэнэнхайрхан, Яруу, Сонгино зэрэг 17 сумын тархвар зүйчээр ажиллах нийт 27 эмч мэргэжилтнийг томиллоо.

“Мал эмнэлгийн зөвлөгөөн-2019” зөвлөгөөнийг 3 дугаар сарын 24-25 -ны өдрүүдэд Улиастай хотод зохион байгууллаа. Зөвлөгөөнд аймгийн засаг дарга Д.Батсайхан, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал эмнэлгийн хяналт эрсдэлийн үнэлгээний газрын дарга Х.Болдбаатар, Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын мэргэжилтэн Д.Эрхэмбаатар, Биокомбинат улсын төсөвт үйлдвэрийн газрын дэд захирал С.Тэсхуяг, аймгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Н.Батбаяр, сумдын мал эмнэлгийн тасгийн дарга улсын байцаагч, тархвар зүйч, аймгийн мал эмнэлгийн газрын эмч, мэргэжилтнүүд зэрэг нийт 122 хүн оролцлоо.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах мал амьтдын тоо, вакцины захиалгыг сумдаас авч нэгтгэн өвчний эпизоотологийн / тархвар зүй / байдлыг харгалзан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хуваарийг хийж баталлаа.

2019 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 1937.5 мянган мал, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд угаалга 1930.0 мянган мал, туулгалт 1020.0 мянган мал, боловсруулалт 150,0 мянган мал нийт 3100,0 мянган мал, 1250,4 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт, бруцеллөз өвчний тандан шинжилгээнд 10,0 мянган хээлтүүлэгч мал, ям өвчин 200 мал, сүрьеэ өвчний тандан шинжилгээнд 200, адууны халдварт цус багадах өвчний тандан шинжилгээнд 2000 мянган мал хамруулахаар мал эмнэлгийн газрын дарга, сумдын засаг дарга, мал эмнэлгийн тасгийн дарга нарын гурвалсан гэрээ байгуулсан.

Цагаанхайрхан, Алдархаан, Баянтэс, Нөмрөг, Тэс сумдаас нийт 6 дээж эмгэгт материал ирж стандарт арга зүйн дагуу шинжилгээг хийж галзуу 5, колибактериоз 1 өвчний үүсгэгч илрэв. Шинжилгээний хариуг холбогдох иргэн аж ахуй нэгжид хүргүүлэн стандарт арга зүйн дагуу зөвлөгөө өгч ажиллалаа.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

6.1.Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Улиастай зах, Газар тариалан, фермер, зүсвэрийн мод зүсэх, Гэрийн эсгий, ноосон дулаалгын материал

үйлдвэрлэх цехийн үйл ажиллагаатай танилцаж байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргалаа. Петровис, Шунхлай, Магнай трейд ХХК-ны 2019 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж ажиллалаа.

Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу Завхан аймгийн Дөрвөлжин сумд үйл ажиллагаа явуулдаг “Шинэтогтох ХХК”-ны албан хүсэлтийг үндэслэж ус ашиглах дүгнэлтийг гаргалаа.

2019 онд Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ойжуулалт, ой нөхөн сэргээлт, ойн цэвэрлэгээ, ойн хөнөөлт шавьж, хортонтой тэмцэх ажлуудын ажлын даалгавар, техникийн нөхцлийг боловсруулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Байгууллагын мод үржүүлгийн талбайгаас модлог мөчир бэлтгэх технологийн дагуу Улиасны 2000, Бургасны 2000 ширхэг харандаан мөчир бэлтгэсэн ба дараа жилд модлог мөчир бэлтгэх талбайд тайралт хийх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Сумдын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, албан байгууллагуудын гадна талбай, нийтийн эзэмшлийн зам талбайн өнгө үзэмжийг сайжруулах, цаашлаад хүн бүр байгалиа хамгаалахад гар бие оролцох боломжийг бий болгох, мод, цэцэг тарих, арчлан хамгаалах түүнийгээ амьдралын хэв маяг болгон хэвшүүлэхийг сурталчлах зорилгоор 5000 ширхэг мандалын цэцгийн үрсэлгээ хийлээ.



Ой хээрийн түймрийн аюултай үе эхэлсэнтэй холбоотойгоор хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган ой бүхий 16 сумын байгаль хамгаалагчид, Түдэвтэй, Тосонцэнгэл сумдын Ойн ангиудтай өдөр бүр утсаар холбогдож жижүүрийн дэвтэрт тэмдэглэн БОАЖЯ-ны түймрээс урьдчилан сэргийлэх хариуцлагатай жижүүрийн утсанд тогтмол мэдээллэж байна.



Мөн аймгийн “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хамгаалах зөвлөл”-ийн хуралдааныг зохион байгуулж энэ онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг хэлэлцүүлж, батлуулахаар бэлтгэн ажиллаж байна.

Байгаль орчин аялал жуулчлалын яам, Цэнгэг усны нөөц, Байгаль хамгаалах төвөөс зарласан гар зургийн уралдаан, видео бичлэгийн уралдаанд манай аймгаас Түдэвтэй, Тэлмэн, Сантмаргаз, Ургамал, Идэр, Улиастай зэрэг сумдаас нийт 24 бүтээлийг явуулснаас Тэлмэн сумын эко клубын хүүхдүүдийн явуулсан нийлэг хальсан уутны видео бичлэгийн бүтээл шалгарч амжилттай оролцлоо.


6.2. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл эхний 2 сарын байдлаар оны үнээр 4 тэрбум 872.9 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 1.9 дахин буюу 2295.4 сая төгрөгөөр өссөн байна. Нийт үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 33.0 хувийг, хүнсний үйлдвэрлэл 5 хувь, хувцас үйлдвэрлэл 7.4 хувь, эсгий эдлэл үйлдвэрлэл 0.6 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 1.5 хувь, өлөн гэдэс үйлдвэрлэл 0.1 хувь, боловсруулсан мах үйлдвэрлэл 52.1 хувь, гурил үйлдвэрлэл 0.1, бусад үйлдвэрлэл 0.2 хувь, хувийг тус тус эзэлж байна.



байгууллаа.

Уг сургалтаар бусад аймагтай туршлага, мэдлэг, ур чадвараа солилцох цаашид хэрхэн ажиллах програм хангамж болон хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал солилцож ажиллалаа.

Монгол улсын газрын шинэтгэлийн үндэсний хорооны ажлын хэсгийн гишүүн Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын орлогч дарга А.Батбаяраар ахлуулсан ажлын хэсэг 2019 оны 03 сарын 04-ний өдөр манай аймагт ажиллалаа. Аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргатай уулзаж газрын харилцааны чиглэлээр хийгдэж байгаа томоохон ажлуудын талаар санал бодлоо солилцон цаашид анхаарч ажиллах зарим ажлуудыг шийдэрлэлээ.





зурж баталгаажууллаа.

2018 онд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хууль, Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой аймгийн улсын бүртгэлийн хэлтэстэй хамтарсан уулзалт зохион байгууллаа.

Аймгийн Барилгын салбарын удирдах ажилтаны зөвлөгөөнийг 30 гаруй аж ахуйн нэгжийн төлөөллийн 40 гаруй инженер техникийн ажилчид болон Улаанбаатар хотын Барилгын хөгжлийн төвийн төлөөллийг оролцуулан 3 сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх Улиастай сумын Баазын район, Хүнс хөдөө аж ахуйн газар, 8, 9-р цэцэрлэгийн усан хангамж, ариутгах татуургын угсралтын ажил, Богдын гол багийн бор дүнзэн байрны хэсэгт шинээр хийгдэх бохир усны шугамын ажил, Товцог багийг бохир усны шугамд холбох ажлуудын схем зураг, зургийн даалгавар боловсруулан гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг зарлууллаа.

Шинээр баригдах Идэр сумын 200 хүний суудалтай соёлын төв, Эрдэнэхайрхан сумын ЗДТГ-ын конторын барилгын цахилгаан, холбооны техникийн нөхцөлийг бүрдүүлэн дэвсгэр зураг дээр тодотгол хийж “Өлзий-Иш” ХХК-нд хүргүүлсэн. “Грийн спарек” ХХК-ний 25 айлын орон сууцны барилга угсралтын ажил дуусаж улсын комисс ажиллуулж хүлээн авах ажлыг зохион байгууллаа.

Мөн Цэцэн-Уул сумын 200 хүний суудалтай соёлын төв “ЦЭХТ” ХХК, аймгийн нэгдсэн эмнэлгийн аюултай хог хаягдалыг шатаах зуухны барилгын ажил “Хэрмээдэй” ХХК шалгаран гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна.

БНСУ-ын зээлийн хөрөнгөөр Улиастай суманд баригдах 25мВт-ын дулааны станцын байгаль орчны үнэлгээ хийсэн талаарх ажлын тайланг Улиастай суманд дулаан үйлдвэрлэх, түгээх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд, иргэдээр

ЛМ програм хангамжийг Web системийг улсын хэмжээнд нэвтрүүлэх сургалтыг 2019 оны 03 сарын 11-ний өдрөөс 03 сарын 14-ний өдрийг дуустал 24 сумын газрын даамлуудад зохион байгууллаа.

Тус сургалтын үеэр 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд гарын үсэг

хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан шийдвэрийг “Эрчим хүчний яам”-нд хүргүүлсэн. Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Алдархаан сумын төвийн шинэчлэл төслийн ерөнхий төлөвлөгөөнд танилцуулга, хэлэлцүүлэг хийлээ.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР